

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, Мягмар гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:**

1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:**

4-30

- 
- 1. Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон  
Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн  
тайлан** 4-27
  - 2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын  
хэсэг байгуулах тухай/** 27-30

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
11 дүгээр сарын 11-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 21 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Р.Сэддорж, А.Ундраа;

Чөлөөтэй: С.Амарсайхан, С.Ганбаатар, Г.Дамдинням, Ц.Мөнхбат, Т.Мөнхсайхан, У.Отгонбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг, Ж.Чинбүрэн.

Байнгын хорооны дарга Б.Бейсен хэлэлцэх асуудлын дарааллын гуравдугаар асуудал болох “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэхийг хойшлуулав./16:24/

**Нэг.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, референт Г.Нямдэлгэр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга Т.Балжинням, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг, Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Буяннэмэх, Хуулийн хэлтсийн дарга Х.Мөнхзул, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Э.Баттулга, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Усны газрын дарга З.Батбаяр, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Г.Хоролмаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батшагай, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх

газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын референт Д.Даваасамбуу, Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Золбоо, Үнэлгээ, мониторингийн хэлтсийн дарга Б.Баярсүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Б.Бат-Эрдэнэ, М.Мандхай, Б.Бейсен нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, С.Одонтуяа, Б.Мөнхсоёл, Б.Бат-Эрдэнэ, М.Ганхүлэг, С.Бямбацогт, Б.Бейсен нар үг хэлэв.

*Уг асуудлыг 17 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Энхгэрэл нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Бейсен хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг татах горимын санал гаргав.

**Б.Бейсен:** Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	11
Бүгд:	20

45.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

**Б.Бейсен:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 16

Бүгд: 20

20.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдсангүй.

*Уг асуудлыг 17 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 32 минут үргэлжилж, 30 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 53 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр,

Мягмар гараг

Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”

танхим

16 цаг 21 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Бейсен:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 53.3 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Гишүүдийн ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна. Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирсэн байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

1.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан.

2 дахь асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай” ийм 2 асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалд оръё. Энэ 3 дахь асуудал Байнгын хорооны тогтоолын төслөөр “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” байсан. Энэ асуудлыг бид нар хойшлуулж байна. Бас дахин хэлэлцэх асуудал байгаа учраас.

**Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцье.**

Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлангийн танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн,

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батбаатар сайд танилцуулна. 5 номерын микрофон.

**Б.Батбаатар:** Улсын Их Хурлын Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9, 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт болон Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 19.4-д заасныг үндэслэн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журмын 3.7-д заасан аргачлалыг баримтлан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнг танилцуулж байна.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд Монгол Улсын 79 хуулийн 263, Улсын Их Хурлын 90 тогтоолын 491 заалт, Байнгын хорооны 69 тогтоолын 290 заалт, нийт 238 шийдвэрийн 1044 заалт бүртгэлтэй байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар хууль, Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт дунджаар 46 хувь байна. Тухайлбал, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд бүртгэлтэй байгаа Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын харьяа агентлаг, аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагаар авч үзэхэд 1044 заалтаас 40.6 хувь буюу 424 нь хэрэгжсэн. 47.7 хувь буюу 498 нь хэрэгжээгүй, 11.7 хувь буюу 122 заалт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж үнэлэгдсэн байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг авч үзвэл:

Хуулийн хэрэгжилт, тайлант оны эхний хагас жилийн байдлаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 11 хуулийн 38 заалтыг төрийн захиргааны төв 12 байгууллага дунджаар 28.6 хувьтай хэрэгжүүлсэн байна. Монгол Улсын 6 хуулийн 25 заалт хэрэгжээгүй бөгөөд уг заалтаар төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны акт, дүрэм, журам, жагсаалт, стандарт зэргийг батлан хэрэгжүүлэх эрх олгосон байна.

Хэрэгжээгүй 25 заалтаар тавигдах шаардлага, норматив, зөвлөмж, тусгай зөвшөөрлийн тоог батлах тус бүр 1 зохицуулалтыг батлан хэрэгжүүлэхээр байна. Тухайлбал, Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 2021 оны шинэчилсэн найруулгаар үрийн технологийн нөөцөд байх таримлын төрөл, нөөцийг бүрдүүлэх, удирдах үйл ажиллагааны болон үр үйлдвэрлэлийн талбайд сортын хянан баталгаа хийх, хянан батлагчийг сургах, давтан сургах, хянан батлагчийн эрх олгох, цуцлах, бүртгэл хөтлөхтэй холбогдсон журам, үрийн чанарыг баталгаажуулан шаардлагатай таримал ургамлын төрөл, зүйлийн жагсаалтыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан хэрэгжүүлэхээр байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд бүртгэгдсэн 7 шийдвэрийн 91 заалтын хэрэгжилт төрийн захиргааны төв байгууллагын 8 яамдад дунджаар 38 хувьтай байна. Улсын Их Хурлын хэрэгжээгүй 2 тогтоолын 49 заалтыг авч үзвэл “Улсын Их Хурлын хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2021 оны 104 дүгээр тогтоолын 1.2 дахь заалтаар Засгийн газарт даалгасан Генетик нөөцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасан генетик нөөц ашигласны үр шимийн төлбөрийг төлөх, төвлөрүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, 2022 оны 3 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүргийн хэрэгжилт үр дүнгүй байна.

### 3. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт.

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан 11 тогтоолын 51 заалтын хэрэгжилт төрийн захиргааны төв 9 байгууллагад дунджаар 70.7 хувьтай байна. Тус Байнгын хорооны 2019, 20, 22, 23 оны 6 тогтоолын 12 заалтын хэрэгжилт үр дүн гараагүй байна. Тухайлбал, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2019 оны 1.1 “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 04/01 дүгээр тогтоолоор өгсөн Гол, мөрний урсац бүрэлдэх эх усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн биелэлтийг нийслэл болон Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт хангасан талаар танилцуулах үүргийн хэрэгжилтийг хангахаар ажлын хэсэг байгуулж, уулзалтууд зохион байгуулсан байх боловч танилцуулга гаргаж мэдээлэх ажлыг бүрэн биелүүлээгүй, үр дүн гараагүй байна.

Улсын Их Хурлын Байнгын хорооны 6 тогтоолын 12 заалтын хэрэгжилтийг тухайн чиг үүргийг хүлээсэн байгууллагууд тайлагнах хугацаанд хэрэгжүүлсэн ажил нь үнэлэгдэхүйц ахиц гараагүй зарим тохиолдолд тогтоолын 1 заалтаар өгсөн хэд хэдэн үүргийн зарим хэсгийг гүйцэтгээгүй, тухайн заалтын хэрэгжилтийг зарим байгууллага ирүүлээгүй байх тул хэрэгжээгүй гэж дүгнэлээ.

Хууль, Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоолын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнгийн тайланг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг, чиглэл өгч, биелэлтийг тооцон ажиллаж байна.

### Дүгнэлт.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд бүртгэлтэй Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 11 хуулийн 38, Улсын Их Хурлын 7 тогтоолын 91 заалт, Байнгын хорооны 11 тогтоолын 51, нийт 29 шийдвэрийн 180 заалт давхардсан бүртгэлтэй байгаагаас 38.3 хувь буюу 69 нь хэрэгжсэн. 47.8 хувь буюу 86 нь хэрэгжээгүй. 13.9 хувь буюу 25 нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж тус тус дүгнэгдсэн байна.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилт дунджаар 45.8 хувьтай байна.

**Б.Бейсен:** Танилцуулга хийсэн Батбаатар сайдад баярлалаа.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя ажлын хэсгийг. Ажлын хэсэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайд Б.Батбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын Тамгын газар Б.Алтантуяа Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүрэг орлон гүйцэтгэгч, Б.Отгонсүрэн Үнэлгээ, мониторингийн газрын зөвлө, Г.Нямдэлгэр Үнэлгээ, мониторингийн газрын референт байна уу? Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Ш.Батбаяр Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Золбаяр Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Т.Балжинням Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын дарга, Ц.Уранчимэг Тусгай хамгаалалттай газрын нутгийн бодлогын газрын дарга, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын дарга, Б.Буяннэмэх Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Х.Мөнхзул Хуулийн хэлтсийн дарга, Б.Баттулга Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, Б.Оюунсанаа Ойн газрын дарга, З.Батбаяр Усны газрын дарга, Г.Хоролмаа Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамнаас Ц.Болорчулуун Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Батшагай Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ц.Мөнхнасан Мал аж ахуйн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас Б.Батцэцэг Газрын дарга, Б.Золбоо Үнэлгээ, мониторингийн газрын дарга, Б.Баярсүх Үнэлгээ, мониторингийн хэлтсийн дарга, Д.Даваасамбуу референт.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Уянга гишүүнээр тасаллаа. Б.Уянгаа гишүүн асуулт асууя.

**Б.Уянга:** Оройн мэнд хүргэе. Их Хурлаас баталсан шийдвэрийн биелэлтүүдийг харахад ер нь л хангалтгүй байгаад байдаг. Тэгээд 50 хувь нь, танилцуулгаас харахад ер нь 50 хувь ядаж хагас нь ч биелсэн зүйлүүд харагдахгүй. Тэгээд хэрэгжээгүй шийдвэрүүдийг нь, тайлбарыг нь харахаар зохион байгуулалт хангалтгүй байлаа, удаашралтай байлаа, дутуу тайлагнасан байна гээд. Энэ тохиолдолд яг ямар хариуцлага байх вэ? Энэ хэрэгжээгүй гэсэн энэ ажлууд нь хэзээ яг хэрэгжих вэ? Тэр дээр нь хяналтыг хэн тавих вэ? Тэгээд бас энэ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар түрүүн Эдийн засгийн байнгын хороон дээр байхад Улсын Их Хурлаас томилогдсон байгууллагуудын бас хэрэгжилт нь ирэхгүй удааширдаг гэсэн хариултууд юу гэж байна лээ. Тэгэхээр одоо гарц нь яг юу байна? Тэр хэрэгжилтийг нь ирүүлдэг болгохоор байна уу? Эсвэл Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь Засгийн газрынхаа доор биш Их Хурал дээр байх ёстой юу, тийм статусын асуудал байгаад байна уу? Зарим энэ шийдвэрүүдийг харахаараа л 2017 оных байх юм, 22 оных байх юм. Одоо хүртэл хэрэгжээгүй гээд. Хэзээ хэрэгжих вэ? Хариулт авъя.

**Б.Бейсен:** 6 номер хариулъя. Нэр, албан тушаалын хэлээрэй.



2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Б.Батцэцэг:** Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар Батцэцэг. Уянгаа гишүүний асуултад хариулъя. Хариуцлагын хувьд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хагас жилээр үнэлсэнтэй холбоотойгоор хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах, мөн хариуцлага алдсан албан хаагчдад арга хэмжээ авах асуудлыг Хяналт хэрэгжүүлэх газраас хариуцлага алдсан албан хаагчдад арга хэмжээ авах асуудлыг 5 яаман дээр томилох эрх бүхий албан тушаалтанд нь саналаа хүргүүлсэн байж байгаа. Саяын Батбаатар сайдын танилцуулгад дурдсан хагас жилээр үнэлж байгаа учраас хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр яамдад төсвийн ерөнхийлөн захирагч нар болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт болохоороо Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл хүргүүлсэн. 2025 оны 11 дүгээр сар 15-ны өдрөөр хэрэгжилтээ буцаж Хэрэг эрхлэх газар дээр ирүүлэх ёстой. Засгийн газрын тухай хуулиараа хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хэрэгжүүлж байгаа. Тэгэхээр хяналтыг хууль тогтоомжоор заагдсан үүргийг хэрэгжүүлэхгүй байгаа асуудал дээр байнгын хяналт тавих чиг үүрэг нь энэ Хэрэг эрхлэх газар дээр байгаа. Яах аргагүй энэ хууль тогтоомжоор үүрэг болгосон заалтуудын хэрэгжилттэй холбоотой бид нарт зарим тохиолдолд Монголбанкнаас юм уу, эс үгүй бол Санхүүгийн зохицуулах хорооноос юм уу Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагуудаас хэрэгжилт авах шаардлага гардаг.

Бид байгууллагуудтай бас нэг бүрчлэн уулзаад явж байгаа. Энэ дээр уг нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгаа хэрэгжилтийг үнэлэх гэж орж ирж байгаа тохиолдолд бид нар хэрэгжилтийг үнэлж байгаа болохоос биш байгууллагыг сайн, муу ажиллаж байгааг үнэлэх гээгүй. Тэгэхээр үйл ажиллагаа, үр дүнг гаргаж ирэх гэж байгаа болохоор байгууллагуудыг бид нарт мэдээллээ ирүүлээч, хийсэн ажлаа бид нарт тайлагнаач, нэгтгээд Засгийн газар дээр, Их Хурал дээр бид тайлагнадаг байя гэдэг асуудлуудыг тавиад харилцан байгууллагууд бас мэдээллээ ирүүлээд ингээд удирдлагуудын түвшинд ойлголцоод явж байгаа ажил байгаа.

**Б.Бейсен:** Энхбаяр сайд гүйцээж хариулъя. Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Гишүүд ээ энд Мэргэжлийн хяналтын газрыг, ерөнхий газрыг татан буулгаж энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналтыг Хэрэглэх газар хариуцуулсан ийм үйл явдал болсон. Тэрний тусгал яг энэ хэрэгжилт дээр гарч ирж байгаа. Салбаруудад бүх хяналтыг тараасан. Тэрийгээ дагаад нөгөө мөрдөж байсан программ хангамж, гэрээ, протоколууд. Жишээлбэл Хүнс, хөдөө аж ахуйн яаманд гэхэд л гаалийн байгууллага, Мэргэжлийн хяналтын газарт ерөөсөө олон чиг үүргүүд шилжиж ирсэн. Энийгээ дагаад тэр бүтэц, зохион байгуулалтыг хийх, программ хангамжийг уялдуулах, хууль тогтоомж, гадна, дотнойгоо гэрээ, гарын үсгээ нийцүүлэх гээд ер нь бүтэц, зохион байгуулалтын нэлээн ажлууд хийгдсэн. Уул нь энэ Монгол Улсын баталж байгаа бүх хууль тогтоомжийн хэрэгжилтийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хариуцаж Их Хурлын өмнө, Засгийн газрын өмнө бүх хэрэгжилтийг гаргадаг, тайлагнадаг байсан юм. Тэр систем унасантай холбоотойгоор ер нь салбаруудын нийт ганц энэ манай энэ Байнгын хорооны 2 салбар биш, улсын хэмжээний.../минут дуусав./

**Б.Бейсен:** Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Ж.Энхбаяр:** Энэ хяналтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцаж хийнэ гэхэд бас чадамжийн хувьд хэцүү. Энэ чинь бүхий л салбарын экспертүүдийн мэргэжлийн том бүрэлдэхүүн хийж ажилладаг цогц байсан хяналт байхгүй юу. Нөгөө талдаа орон тоогоор нэлээн хязгаарлуулчихсан. Яамнууд маань бодлогын яам гэдэг бид нар том зорилтыг 2000 оны эхээр хийгээд яамд чинь бодлогын яам болчихсон юм. Зөвхөн бодлого боловсруулна. Үйл ажиллагаанаас оролцохгүй гэдэг талдаа явсан. Мэргэжлийн хяналтыг салбаруудад нь өгөөд эхлэхээр чинь бодлогын яамнууд маань үйл ажиллагааны яам болж хувирсан. Тэгээд энэ шилжилт, өөрчлөлтийг бид нарт ойлгоогүй дутуу хийчихсэн байхгүй юу. Дутуу хийгээд огцом улс төрийн шалтгаанаар Мэргэжлийг татан буулгаж ингэж тараасантай холбоотойгоор нөгөө бодлогын яам нь үйл ажиллагааны чиглэл нь ч зохион байгуулалтын хувьд хэцүү, орон тоо бүтцийг нь бид нар дээд зэргээр хязгаарлаад багасгачихсан байдаг. Том салбарын хяналтыг улсын хэмжээний хяналтыг яамнуудад нь өгчихсөн байдаг. Яам бодлогоо хийх үү, өөрийнхөө бодлогыг өөрөө хянах уу? Тэгээд энэ хянаснаа.../минут дуусав./

**Б.Бейсен:** Уянгаа гишүүн тодруулах уу? Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар маань би 1 асуулт асууя. 1 номерт яамд дээр холбогдох албан тушаалтнууд өөрсдөө хэр мэргэжлийн байгаа вэ? Энэ дээр та нар дүн шинжилгээ хийсэн үү? Магадгүй Төрийн албаны зөвлөл хариуцах ёстой гэж хариулах байх. Мэргэжлийн бус боловсон хүчинтэй холбоотой асуудлаас улбаатайгаар хуулийн хэрэгжилтийн хяналт хийгдэхгүй байгаа ний нуугүй хэлэхэд.

Хоёрдугаарт, яагаад хяналтын хэрэгжилт сул байгаа вэ гэдэг дээр дүн шинжилгээ гаргаад тодорхой хэмжээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар дамжуулаад та бүхэн арга хэмжээ авах ёстой. Зөвхөн Улсын Их Хурал, Байнгын хороодод асуудал оруулж ирээд хаядаг биш уг асуудал нь хаанаа байна вэ гэдгийг тодорхойлоосой гэж хүсэж байгаа юм. Тэр утгаараа ч гэсэн тухайн үеийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг, Мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаж танай байгууллагыг байгуулж байсан. Би тухайн үед татан буулгах талд нь санал өгөөд явж байсан хүн. Яагаад би ингэж хэлж байна гэхээр тухайлбал энд байгаа байхгүй юу Улсын Их Хурлын 3 тогтоолын 6 заалтын 2-5 жилийн хугацааны хэрэгжилтийн тайланд ахиц гараагүй буюу журмын 6.6-д зааснаар биелэлт нь удаашралтай байна.

Тухайлбал, Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын 2020 оны 5 сарын 7-ны өдрийн 46 дугаар тогтоолын 4 дэх заалтаар байгалийн нөөц болон дурсгалт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч байгаа газар нутгийн хилийн заагийг тогтоохыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан боловч 5 жилийн хугацаанд биелэлт 0 хувь буюу үр дүнгүй байна. Яагаад? Би энийг асуух гэж байгаа юм. 5 жилийн хугацаанд Засгийн газар ажил хийгээгүй гэж дүгнээд байна шүү дээ. Яагаад вэ? Хуульдаа байгаа юм уу, салбартаа байгаа юм уу, орон нутагтаа байгаа юм уу, санхүүжилтдээ байгаа юм уу? Яагаад бүхэл бүтэн 5 жилийн хугацаа энэ хэрэгжихгүй байгаа вэ гэдэгтэй холбоотой асуудал хөндөгдөөд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр би 2 дахь нь асуултад хариулт авмаар байна. Ер нь жишээлбэл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт намайг сайд байхад 21 хувьтай байсан юм. Сайдаар очиж байхад. АТГ-тай хамтарч ажилласны

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хүчинд намайг сайдаа, ажлаа өгөхөд 63 хувьд очиж байсан. Зөвхөн самар гэхэд 1.2, 3 доллар байсан нь 6.4 доллар хүртэл өсөж байсан байхгүй юу. Хэрэгжилт, хяналт байхгүй байсантай л холбоотой асуудал. Тэгэхээр энэ хуулийн хяналтыг Улсын Их Хурал болон Байнгын хорооноос өгч байгаа энэ хууль тогтоомжийн тогтоолын хяналт дээр яагаад алдаа гараад байна вэ гэдгийг та бүхэн яаж дүгнэж байгаа вэ гэдэг ийм 3 асуултыг асууя. Баярлалаа.

**Б.Бейсен:** 6 номер хариулъя.

**Б.Батцэцэг:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Яах аргагүй яаман дээр холбогдох албан тушаалтнууд нь мэргэжлийн байна уу гэдэг асуудал Төрийн албаны зөвлөл эрх хэмжээний асуудал. Миний мэдэхээр Төрийн албаны зөвлөл төрийн захиргааны төв байгууллагууд дээр хүний нөөцийн аудит хийгдээд явж байгаа. Бид Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллага, төрийн захиргааны байгууллагын нийтлэг чиг үүрэгт чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг 26 оны 1 сардаа багтааж хийхээр Хяналт хэрэгжүүлэх газар, Хэрэг эрхлэх газар Төрийн албаны зөвлөлтэй хамтарсан ажлын хэсэг явж байгаа. Үүн энэ дээр чиг үүрэг, албан хаагчдын тоо, хуульд заасан чиг, үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж байна уу гэдэг дээр бид нар бас үр дүн гарах болов уу гэж бодож байгаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр та бүхэн хамтраад ямар арга хэмжээ авч байна вэ гэхээр яах аргагүй энэ хууль тогтоомжийн хэрэгжилт гэлтгүйгээр бид нар саяхан 9 сард таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүд гээд ингээд хагас жилээр үнэлэгдэх ёстой баримт бичгүүдийг үнэлсэн хэд хэд хэдэн шалтгаан, дотоод, гадаад хүчин зүйл дээр бас бид нар байна уу гэж харж байгаа.

Нэгдүгээрт, тогтолцооны хувьд бид нар хууль тогтоомжийн кодификац хийх ажлыг зайлшгүй хийж хэрэгжүүлэх шаардлагатай.

Хоёрдугаарт нь ер нь хуулийг бид нар жил хагас жил тутамд үнэлэх ёстой үнэлгээний объект мөн үү, үгүй юү гэдэг дээр бид нар бас бодох хэрэгтэй. Яагаад гэвэл хууль тогтоомжийн хуулиараа бид нар 5 жилд хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг 5 жил тутамд тухайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь бас хийж хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг Хууль тогтоомжийн хуулиар. Тэгэхээр хуулийн хяналтад байгаа заалтуудыг харахаар нийтлэг байдлаараа дандаа журам батлах заалтууд авсан байдаг. Салбар салбарт бас тухайн албан хаагчдын хариуцлага, манлайллын асуудлууд байна. Зарим 2014 оноос хойш батлагдсан хууль дээр дүрэм, журам батлаагүй салбарын яам байхад 2-хон жилийн хугацаанд хуульд чиглэл, салбарынхаа мөрдөгдөж байгаа бүх хуулийг дагах дүрэм, журмуудаа баталчихсан салбарын яамнууд ч гэсэн байгаа.

Бид нар дотоод хяналтыг сайжруулах, хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, бодлогын баримт бичгээр хүлээсэн үүргээ төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлагналтыг хариуцаж байгаа албан хаагчдад сургалт, мэдээллээр хангах энэ 2025 оноос хойш үнэлгээг үр дүнд суурилж хийх гэдэг аргачлалаар явж байгаа. Тэгэхээр энэ аргачлалаа таниулан мэдээллээр хангах, хамтарсан тайлан дээрээ анхаарах ажлуудыг 2025 оны 6 сард 2025 оны 43 дугаар тогтоол батлагдсанаас хойш мэдээлэл солилцох, мэдээллээр хангах ажлуудыг тасралтгүй хийгээд явж байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Яагаад үр дүн гарахгүй байгаад байна вэ гэхээр гадаад хүчин зүйлийн төсөв, санхүү, байгууллага болгон дээр салбарын сайд болгон дээр зохицуулалтаасаа хамаараад янз бүрийн асуудлууд гарч ирж байна. Төсөв, санхүү хураагдсан асуудал байна. Зарим нь болохоороо хуулийн төсөлд саналаа тусгалаа, эс үгүй бол журмын төсөл хэлэлцэгдэж байна гэдэг буюу процесс тайлагнаад явчихсан юмнууд маань 2025 оны 43 дугаар тогтоолоороо 85 хүртэл хувьд хүрсэн бол хэрэгжээгүй гэдэг, үр дүн гараагүй гэдгээр үнэлэгдэж байгаа учраас бас ийм өндөр хувьтай гарч ирсэн байх магадлалтай.

85-аас дээш байх юм бол бид нар үр дүнд хүрсэн гээд үнэлгээг ерөөсөө энэ жилээс эхлээд өмнө нь 30, 70, 100-гаар үнэлдэг байсан үр дүн гарсан, гараагүй гэдэг 2 төрлийн л үнэлгээ хийдэг болсонтой холбоотойгоор бас ийм өндөр хувьтай харагдаж байж магадгүй юм.

Мэдээж Засгийн газрын бүтцэд ажиллаж байгаа болон нутгийн захиргааны байгууллагуудын асуудал хариуцсан албан хаагчдын хариуцлагын асуудал байгаа.

**Б.Бейсен:** 6 номер гүйцээж хариулъя.

**Б.Батцэцэг:** Тэрийг нь бид нар хагас жилээр ажлаа эрчимжүүлэх, энэ тайлагналт дээр гаргасан алдаа, дутагдлыг сайжруулах чиглэлээр томилох эрх бүхий байгууллага, албан хаагчид нь заримд нь хариуцлага тооцох санал хүргүүлсэн. Нийтлэг байдлаараа чиглэл хүргүүлсэн байж байгаа. Тэгэхээр яг энэ ажлын үр дүн нь 2025 оны хууль тогтоомжийн жилийн эцсийн тайлангаар бас илүү тодорхой гарч ирэх болов уу гэж бодож байна.

**Б.Бейсен:** Бат-Өлзий гишүүн тодруулъя. Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар байгуулагдаад би буруу ойлгоогүй бол 2 жил 11 сарын хугацаа өнгөрч байна. 2 жил 11 сарын хугацаанд өөрийн чинь өнөөдөр ярьж байгааг сонсохоор танай байгууллага өөрөө чадамжтай юм уу гэдэг асуудал хөндөгдөж байна. Ний нуугүй хэлэхэд. Танай байгууллага Засгийн газрын түвшинд явж байгаа бүх агентлаг, яам, төрийн байгууллагуудыг хянах чадавх танай байгууллагад байгаа юм уу, хүн хүч чинь хүрч байгаа юм уу? Би түрүүн асуухдаа яамнуудын холбогдох албан тушаалтнууд мэргэжлийн байх ёстой шүү. Энэ чинь чадаж байгаа юм уу гэж асуусан. Таны хариултаас бүүр даваад танайх өөрөө энийгээ чадаж байгаа юм уу гэж асуухаас өөр аргагүй байдал руу орж байна. Нэг.

Хоёрдугаарт, тусгай хамгаалалттай газар нутагт авах хил, заагтаа өөрчлөлт оруулахтай тухай холбоотой асуудал чинь асуугаад байгаа шүү дээ. Энийг надад яг тодорхой хариулаад өгөөч.

**Б.Бейсен:** Байгаль орчны яам, 9 номер. Дараа нь 6 номер хариулаарай. 6 номерыг эхлээд хариулъя.

**Б.Батцэцэг:** Байгууллагын чадамжийн хувьд Засгийн газар дахь хяналт хэрэгжүүлэх тухай хуульд зааснаар манай байгууллага үндсэн хэд хэдэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Нэгдүгээрт, үнэлгээ, мониторинг хийх, иргэдийн өргөдөл, гомдол болон Засгийн газар, Ерөнхий сайд, Тэргүүн Шадар сайдын чиглэл болгосноор хяналтын ажил хийх, тандалтын ажил хийх буюу та бүхний, бид нарын илүү их мэддэгээр чинь процессын дахин инженерчлэлийн ажлуудыг хийж байгаа. Иргэдийн өргөдөл, гомдлыг авч шийдвэрлэх гээд үндсэн ийм 4 чиг үүрэгтэй үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байгаа.

Магадгүй энэ салбарын хяналт, дотоод захиргааны хяналт хоёр холигдоод байж магадгүй. Хяналт хэрэгжүүлэх газар захиргааны хяналтыг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын дотоод хяналтын чиг үүргийг манай байгууллага хэрэгжүүлж байгаа. Хуулиар олгосон чиг үүргийнхээ хүрээнд бид өнөөдөр Засгийн газраас 150 хүртэл хүний орон тоотойгоор манай.../минут дуусав./

**Б.Бейсен:** Бат-Эрдэнэ гишүүнд тодруулъя.

**Б.Бат-Эрдэнэ:** Та хэд ингээд өөрөө өөрсдийгөө л ороосон юм яриад байх юм. Захиргааны хяналт гэдгийг чинь мэдэж байгаа шүү дээ. Танайх мөрдөн шалгах, хянах байгууллага биш. Би та нараас мөрдөн шалгахтай холбоотой асуулт ерөөсөө асуугаагүй. Та хэд энд ингээд үнэлгээ гаргаад дүгнээд байгаа байхгүй юу нэг талдаа. Үүний чинь ард хүмүүсийн хувь тавилангийн асуудал яригдаад байна шүү дээ. Байгаль орчны яамны холбогдох албан тушаалтнууд болон зүгээр ажлаа хийгээд явж байгаа мэргэжилтнүүд та нарын үнэлсэн үнэлгээгээр үнэлэмж нь унаад байгаа байхгүй юу.

Гэтэл энийг Байгаль орчны яам өнөөдөр хийх боломжгүй. Нөхцөл байдал нь ийм. Газрын хууль, Тусгай хамгаалалттай газар, нутгийн тухай хууль, Бэлчээр ашиглалттай холбоотой асуудлууд дээр гарсан баахан журам, дүрмүүд чинь, улсын төсөв, маш олон асуудлаас улбаатайгаар Засгийн газарт өгсөн Байнгын хорооны тогтоол 5 жилийн хугацаанд “0” хувьтай байгаа учир шалтгаан чинь тэнд байгаад байгаа байхгүй юу.

Гэтэл та нар жил болгон 0 гээд үнэлээд байгаа байхгүй юу. Яагаад л гэж би асуугаад байгаа юм. Энэ учир шалтгааныг та нар мэдэж байна уу үгүй юу гэдгийг л би асууж байгаа юм. Би.../минут дуусав./

**Б.Бейсен:** 6 номер хариулъя.

**Б.Батцэцэг:** 2025 оны 43 дугаар тогтоолоор өмнө нь бид нар энэ процессыг хувьчилж, үнэлээд 30-100 хувиар үнэлгээгээр тавиад явж байсан. Энэ 20 шинэ тогтоолоор ямар боломж гарсан бэ гэхээр газар дээр нь очиж үнэлгээ хийх боломж энэ тогтоолоор шинэ зохицуулалт орж ирсэн. Түүний дагуу Хяналт хэрэгжүүлэх газраас Засгийн газрын нөгөө хөрөнгө оруулалтаар, улсын хөрөнгө оруулалтаар болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд дээр үр дүн гараагүй гэж үнэлэгдсэн төсөл, хөтөлбөрүүд дээр газар дээрх хяналт шалгалтыг хийх ажлыг ажлын хэсэг байгуулаад ажиллаж байна.

Нөхцөл байдлын хувьд энэ чинь нэг талаасаа бид нар үнэлгээ, үнэлгээгээ оруулж ирээд байгаа боловчиг хяналтад авч байгаа заалт нь Их Хурал дээр байж байгаа. Тэгэхээр Засгийн газрын нийт яамдаас өгсөн нийт заалтыг хасуулъя гэсэн.../минут дуусав./



2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Б.Бейсен:** 6 номер гүйцээж хариулья.

**Б.Батцэцэг:** 1374 заалтыг хяналтаас хасаж өгөөч буюу нэгдүгээрт хэрэгжилтийн хувьд ач холбогдлоо алджээ. Хоёрдугаарт, хэрэгжихсэн байна. Гуравдугаарт, энэ хууль тогтоомж хоорондын нийцлийн асуудал байна гэдэг саналуудыг хүргүүлсэн. Зарим нь хяналтаас хасагддаг, зарим нь хасагддаггүй асуудал байгаа.

Үнэлгээний аргачлалын хувьд Засгийн газраас баталсан тогтоолд заасан аргачлал, томьёоллоор үнэлээд гаргаж ирж байгаа үзүүлэлтүүд.

**Б.Бейсен:** Байгаль орчны яам хариулах юм уу? Батчимэг гишүүн асуулт асууя.

**П.Батчимэг:** Өнөөдрийн энэ Байгаль орчин манай энэ Байнгын хороогоор орж ирж байгаа энэ асуудал зайлшгүй ярих, хэлэлцэх ёстой асуудал гэж бодож байна. 6 номер дээр байгаа тэр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналтын газрын дарга, төлөөлөл эмэгтэй танаар өнөөдөр гишүүд бас хичээл заалгамааргүй байна л даа. Тэгэхээр та нэлээн их цаг хугацааг авч гишүүдийн асуултад хичээлээ заачихлаа.

Монгол Улсын хууль, энэ Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг өнөөдөр хагас жилээр, эхний хагас жилээр үнэлэлт, дүгнэлт өгсөн энэ тайлан сонсож байгаа байхгүй юу. Гэтэл энэ таны орж ирсэн энэ материалаас хараад манай энэ Байнгын хорооны яг чиглэлийн 2 яамны тогтоол, шийдвэр, хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал энэ хагас жилээр чинь маш хангалтгүй гарч байна л даа. Ер нь эндээс улбаатай Засгийн газар өөрчлөгдөж, нэг Засгийн газар огцорч, дараа нь дахиад Засгийн газар гарч ирэхдээ эсвэл бүтцээ том тэлдэг, эсвэл хумьдаг байдалтай иймэрхүү энэ хэлбэлзэл, дураараа энэ байдлаас болоод л завсар хоорондын энэ ажил уналт, ингээд л энэнээс улбаатай энэ бүх тогтоол, шийдвэр, хууль чинь ингээд уналт, хэрэгжилт нь ийм муу орж ирж байна шүү дээ.

Байнгын хороогоор энийг хэлэлцэхгүйгээр цаашаагаа дараагийн хагас жил, бүтэн жил энэ тайлан яаж явж Их Хурлаар хэлэлцэгдэх юм, энэ Байнгын хороогоор дахиж хэлэлцэгдэх юм? Цаг хугацааны хувьд энэ чинь бараг намрын чуулгын 9 сарын 15 аль хэдийн бараг орчих ёстой асуудал шүү. Одоо 2 дугаар хагас, бүтэн жилийн бараг энэ юу үзэх гарч ирэх гэж байна шүү дээ тайлан. Тэгтэл ингээд 11 сарын, өнөөдөр хэдэн юм? 11 болчихоод байж байхад эхний хагас жилээ гэж яриад орж ирээд хичээл заана гэвэл тийм юм байхгүй за.

Тэгээд энэ байдалдаа яаж дүгнэлт хийгээд 2 дугаар хагасын тайлан гарч ирэхэд ямар үзүүлэлттэй яаж гарч ирэх юм? Энэ тогтоол, шийдвэр энэ хуулийн хэрэгжилт ийм хангалтгүй явна гэдэг чинь энэ доод, дунд шатандаа төрийн ажил ямар явж байгааг өнөөдөр харуулж байна. Та энд болсон болоогүй ийм юм ярьж байхын оронд яг таг хариулах ёстой шүү дээ. Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яаман дээр яг тийм тийм тогтоолууд тэгж хэрэгжиж байна, хууль ингэж хэрэгжиж байна. Одоо ер нь ийм юман дээр шүүмжлэлтэй хандмаар байна гэж дүгнэлт өгөх ёстой.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Байгаль орчин, уур амьсгалын яаман дээр бас адилхан. Хэчнээн тогтоол Байнгын хороо баахан тогтоол гаргадаг. Тэрний хэрэгжилт өнөөдөр ямархуу байгааг бид мэдэх ёстой шүү дээ. Тогтоолоо баталчихдаг. Тэгсэн мөртөө хэрэгжилтээ дүгнэж, сонсож чадахгүй байна гэдэг маш харамсалтай байна. Та тэгэхээр дараагийн удаа нэлээн бас чанар, чансаатай энэ юмаа оруулж ирэх хэрэгтэй л гэж би бодож байна.

**Б.Бейсен:** Үг хэлсэн үү? Үг хэллээ. Мандхай гишүүн асуулт асууя.

**М.Мандхай:** Би бараг Батчимэг гишүүнтэй адилхан л юм хэлэх гээд л бухимдах гээд байна л даа. Хөдөө аж ахуйн салбарын асуудлыг бас санаа зовж ингээд бас хөгжөөсэй гэж бодож явдаг гишүүний хувьд ингээд харахаар хөдөө аж ахуйн салбарыг маш л хүнд хэрэгжилттэй байгаагаар л бичсэн байна л даа. Үндсэндээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос эрхлэх асуудал Улсын Их Хурлын шийдвэрт 6.9 хувийн биелэлттэй. Өгсөн үүрэг, даалгавар ингээд дандаа 8 хувийн биелэлттэй, 6 хувийн биелэлттэй гээд энэ үндсэндээ ерөөсөө биелээгүй шахуу заалтууд байна л даа. Тэгээд энэ дээр ингээд хараад үзэх юм бол хүнсний аюулгүй байдалтай холбоотой нэлээн ноцтой асуудлуудыг хүртэл дурдсан байгаад байгаа юм.

Тэгэхлээр ер нь би ингэж асуух гээд байгаа юм. Үгүй тэгээд энэ Улсын Их Хурлын шийдвэр хэрэгждэггүй юм бол энэ хууль тогтоох байгууллагын энэ хяналтын чадвар, улс төрийн энэ хариуцлагын асуудал угаасаа суларна биз дээ. Тэгээд бид нар энэ хэрэгжихгүй байгаа асуудлыг тэгээд яах ёстой юм, гишүүд яах ёстой юм? Танай байгууллага хүн, хүч, бүтэц гаргаад энэ асуудал дээр судлаад ингээд Засгийн газар хэрэгжүүлэх ийм тайлангаа танилцуулаад шийдвэр биелүүлэх ингээд ажил явуулдаг ч гэсэн энэ ингээд үр дүнгээ өгөхгүй байгаад байгаа юм бол энэ чинь өөрөө тухайн өөрөө улсын салбарын асуудал яригдах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр та бүхэн яг яг ямар бид нар шийдэл гаргах ёстой юм, яах ёстой юм бэ гэдэг дээр би хариултыг чинь нэгдүгээрт сонсчихмоор байна.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын тогтоол энэ Байнгын хорооноос бас адилхан давхар аж ахуйн нэгж хяналт шалгалт хийсэн байна. Эндээс ингээд тодруулаад асууя гэхлээр хариулах хүн байгаа юу Байнгын хорооноос? Байнгын хороо бас өөрсдийнхөө давхар хянасан энэ энэ хяналт шалгалтынх нь энэ гаргасан дүгнэлт чинь өөрөө хэр мөргөж байгаа юм бэ? Энэ дээр хариулт хэлээд өгөөч. Үндсэндээ энэ хүнсний аюулгүй байдал тэр чигтээ алдагдах түвшинд байна гэдгийг ингээд энэ тайлан дээр оруулсан байна. Бид нар ингээд импортын хамаарал гүнзгийрч байна. Дотоодын үйлдвэрлэл нэмэгдээд байгаа юм шиг боловчиг бүтээмж ерөөсөө байхгүй. Жил ирэх тусам бид нар хүнсний импортоос хамааралтай ийм эрсдэлд орж байна. Энэ нь юун дээр нөгөө талдаа харуулж байгаа вэ гэхлээр үнийн өсөлт, инфляцтай шууд хамааралтай. Иргэдийн одоо яг энэ сагсан дахь хэрэглээний бүтэц угаасаа хомсдож байгаа, багасаж байгаа. Тэгэхээр энэ хүнсний үнийн тогтворгүй байдал хүртэл үүсээд ийм эрсдэлүүд үүсээд байна. Үүнийг нь ингээд энэ тайлан дээр угаасаа тусгачихсан байгаад байна. Хүнсний хяналт энэ түүхий эдийн үйлдвэрлэл энэ хүнсний хяналтын энэ лабораторийн шинжилгээ хийх дүгнэ.../минут дуусав./

**Б.Бейсен:** 6 номер хариуля.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Б.Батцэцэг:** Мандхай гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар Хяналт хэрэгжүүлэх тухай хууль, Засгийн газар дахь Хяналтын тухай хуулиараа яг одоо энэ яамдаас, нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн тайланг тусгай Засгийн газраас тогтоосон аргачлалаар үнэлээд л оруулж ирж байгаа нь энэ. Байгууллагуудын тайланг зарим тохиолдолд чанарын хувьд шаардлага хангахгүй байгаа, эс үгүй бол хийсэн ажлаа зохистой тайлагнахгүй байгаа асуудал гарч байгаа. Тэрийг бид нар Засгийн газрын хуралдаан дээр танилцуулаад сайжруулах чиглэлийг Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр байгууллага тус бүрд нь тухайлан үүрэг болгоод явсан байж байгаа.

Хяналт хэрэгжүүлэх газраас хийсэн тайлан маань хуулиараа 9 сарын 1-ний дотор Засгийн газарт хагас жилийн тайлан танилцуулагдаад түүнээс 30 хоног билүү Их Хурлын Тамгын газар билүү хариулах байх, 30 хоногийн дотор Их Хурал дээр үнэлэгдээд та бүхэнд тараагдсан материал маань 2 янзын үнэлгээ орж ирж байгаа байх.

Нэг нь Засаг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас тавьсан үнэлгээ, нөгөөх нь Их Хурлын Тамгын газраас тавьсан үнэлгээ орж ирж байгаа байх. Тэгэхээр тэрийг илүү Тамгын газрынхан илүү тодорхой хариулах болов уу гэж бодож байна.

Байнгын хороо болгон дээр хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор өөр өөр харилцан адилгүй цаашид авч хэрэгжүүлэх ажлын саналууд гарч ирж байна лээ. Би бүх Байнгын хороон дээр хууль хэрэгжүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг танилцуулсан. Зарим Байнгын хороон дээр ажил сайжруулах Засгийн газарт чиглэл өгөх тухай асуудал яригдаж байсан. Зарим нь ажлын хэсэг байгуулах асуудал яригдаж байсан. Тэр нь Их Хурлын тухай хуулиараа Байнгын хорооны эрх мэдлийн асуудал болов уу гэж бодож байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд би яг Засгийн газар төлөөлөх эрх бүхий этгээд биш учраас сайд илүү тодорхой хариулах байх.

**Б.Батцэцэг:** Мандхай гишүүн тодруулъя.

**М.Мандхай:** Тийм тэгэхлээр мэдэхгүй. Би бол танай бүтэц ер нь бас байх шаардлагатай ч юм болов уу даа гэдэг дээр эргэлзэж л байна. Яг ийм. Үндсэндээ Улсын Их Хурал болон Байнгын хорооны гаргаж өгч байгаа энэ тогтоол, шийдвэр чинь зөвлөмж биш шүү дээ. Энэ чинь төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэг байхгүй юу. Тэгээд ингээд ийм асуудлууд байгаа гэдгийг нь бид нар мэдсээр байж ингээд зүгээр ийм сонсоод өнгөрдөг байх юм уу Байнгын хорооны даргаа? Энэ чинь бүхэл бүтэн бид нар зүгээр сануулаад өнгөрдөг биш энэ чинь хариуцлагын тогтолцоо биз дээ? Хариуцлага тооцдог ийм тогтолцоо руу бид нар шилжүүлэхгүй бол ингээд баахан тайлан нь хийсэн болдог, нөгөөх нь сонсоод асуусан болдог. Эндээс ямар ч шийдэл, үр дүн гарахгүй. Энд үндсэндээ энэ Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоол, шийдвэр чинь ерөөсөө биелэгдээгүй 10 хувьд ч хүрэхгүй ийм биелэлттэй яваад байх юм уу? Бид нар энийг нь ингээд улсын төсөв батлаад хэрэгжүүлээд л явдаг. Хэрэгжилт нь биелдэггүй ийм л.

**Б.Бейсен:** Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хэрэг эрхлэх газрын дарга Бямбацогт сайд ирсэн байна. 5 номер Бямбацогт сайд хариулъя.



2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**С.Бямбацогт:** Энэ хууль, тогтоолын хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих Улсын Их Хурал дээд хяналтаа тавьж байгаа. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар тодорхой бас хариуцлага ярих боломж нь нээлттэй байгаа. Мөн бас Засгийн газар ч гэсэн бас улирал болгон, сар болгон төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны байгууллагууд, бусад байгууллагууд дээр хяналтаа тавиад ажлыг нь үнэлээд дүгнээд явж байгаа. Өнөөдөр оруулж ирж байгаа энэ танилцуулга бол үндсэндээ хагас жилийн хууль тогтоомжийн шийдвэрийн биелэлтийн талаар хагас жилийн тайлангаа бид нар мэдээлэл өгч байгаа. Жилийн эцсээр нэгдсэн тайлан, нэгдсэн дүгнэлтээ гаргаж танилцуулна. Энэ үед үндсэндээ Их Хурлын тухай хуулиар болон Их Хурлын тухай хууль, Хяналт шалгалтын тухай хуулиараа холбогдох арга хэмжээ авах, шийдвэрүүд гарах бололцоотой. Мөн Засгийн газар ч гэсэн энэ хууль биелүүлдэггүй, хууль тогтоомжийн биелэлтийг хангалтгүй хэрэгжүүлдэг энэ.../минут дуусав./

**Б.Бейсен:** Бямбацогт дарга гүйцээж хариулъя.

**С.Бямбацогт:** Албан тушаалтнууд дээр хариуцлага тооцох энэ асуудлыг бас ярина. Ер нь ингээд тайлангуудыг аваад үзэж байхад их олон янз байдаг юм байна лээ. Дарга нар өөрсдөө дотоод ажлаа тайлагнахдаа аягүй сайн гүйцэтгэлтэй гарлаа гэдэг. Албан хаагч нар өөрсдийнхөө тайлангаа гаргахдаа маш сайн ажиллаж байгаа гэж тайлагнадаг. Дээд байгууллага нь ингээд хянаад, шалгаад явахаар Засгийн газрын түвшинд ирэхээрээ хангалттай биш байдаг. Засгийн газраас Улсын Их Хурал руу ороод ирэхэд ахиад хангалттай биш байдаг. Тодорхой жишээ ярих юм бол юу гэдэг юм яам өөрсдийнхөө үйл ажиллагааг бид 90 хувьтай энэ жил төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлсэн гээд тайлагначихсан байхад Засгийн газар дээр дүгнэхэд тэр 60 хувьтай болчихдог. Их Хурал дээр ирэхээр 40 хувьтай болчихдог. Яг таны хэлж байгаа энэ асуудал хаа сайгүй байгаад байгаа юм.

Тийм болохоор л энэ ерөөсөө л нэгэнтээ бодлого гарсан бол бодлого хэрэгжсэн нь уу, үгүй юү гэдгийг хэн ч үнэлсэн, хэн ч дүгнэсэн, яаж ч хянасан хаана ч адилхан байх энэ зарчмыг л бид нар бий болгох ёстой. Энэ зарчмыг. Энийг бий болгох гээд бас тодорхой ажлууд хийгдээд явж байгаа гэдгийг бас танд хариулъя.

**Б.Бейсен:** Мандхай гишүүн тодруулъя.

**М.Мандхай:** Түрүүн яг энэнтэй холбоотой, тайлагналтай холбоотой асуудлаар яг танай мэргэжилтэн бас хэлж байсан. Үндсэндээ тайлангаа явуулахдаа нэг бол хуучин, өмнөх тайлангаа зүгээр сору, past хийж өгч явуулаад эсвэл зүгээр ямар ч нөгөө үр дүн нарийн тооцоогүй, судлаагүйгээр ямар ч байсан бөглөөд явуулчихдаг ийм л үр дүнтэй л бид нар тайлан сонсоод байгаа юм байна. Тэр дээр бас анхаарна биз дээ гэж хэлмээр байна.

**Б.Бейсен:** 5 номер Бямбацогт сайд хариулъя.

**С.Бямбацогт:** Мандхай гишүүний ярьж байгаа маш зөв асуудал. Ингээд юу гэдэг юм өмнөх тайлангаа сору, past хийгээд тавьчихдаг. Түрүүн бас гишүүн хэлж байна лээ. Иймэрхүү байдлаар, эс үгүй бол ингээд тийм хэлбэрийн төдий хариулдаг, тайлангаа тайлагнадаг иймэрхүү үйл явдлууд үйл ажиллагаанууд дээр хариуцлага тооцоод эхэлсэн. 5 яаманд тухайлах юм холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох ийм шийдвэр гаргасан.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Гүйцэтгэлийн үнэлгээ ил тод болгож байгаа. Төрийн захиргааны бүх албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг ил тод болгож байгаа. Дарга үнэлээд даргын үнэлсэн нь зөв байсан уу, буруу байсан уу гэдгийг иргэд олон нийт бүх хүн болгон ил тод мэддэг болгож байгаа. Нэг яамны ажилтан, албан хаагч энд хүнд сурталтай байна, ажлаа хийдэггүй гээд байдаг. Гэтэл дарга нь үнэлэхдээ маш сайн ажиллаж байна гээд үнэлчихдэг. Тэр үнэлгээг ил тод тавьчихаар яагаад ажлаа хийдэггүй, цагтаа ирдэггүй ийм хүн ингэж үнэлэгддэг юм бэ гээд иргэд, олон нийтэд ил тод болчихоор шахагдаад эхлэхээр энэ үнэлгээ илүү хариуцлагатай болно.

**Б.Бейсен:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын Тамгын газраас Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд. Үг байгаа. Шийдвэрийн биелэлтийг хийсэн тайлангаас үзвэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар 9 хуулийн 20 хэсгийн биелэлт нь 15 хувьтай. Улсын Их Хурлын 7 тогтоолын 92 заалтын биелэлт нь 4.5 хувьтай. Байнгын хорооны 11 тогтоолын 51 заалтад биелэлт нь 7.8 хувьтай. Нийт 27 шийдвэрийн 163 хэсэг, заалтын биелэлт 6.9 хувьтай гэж үнэлэгдсэн байна.

Мөн Усны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг ирүүлээгүй гэж тайлагнасан байна. Энд бас энэ юутай холбоотой гэвэл энэ харьяа агентлаг, яамдын газрын дарга нар, хэлтэс, тасгийн дарга нарын хариуцлагагүй байдал. Төрийн ажил, Их Хурлын тогтоол, шийдвэр тасралтгүй явж байх залгамж халаа гэж байх ёстой. Гэтэл энэ ажиллаж байгаа мэргэжлийн хариуцлагагүй байдлаас тайланг нь гаргаж өгдөггүй, ирүүлдэггүй. Ажил хийж байгаа мөртөө ирүүлэхгүй ингээд үлдээчихдэг.

Тийм учраас энэ дээр бас анхаараад салбар салбарын хариуцлага тооцохгүй бол ингээд төрийн ажлыг ингээд гацаах тийм аюул тулгараад байна. Жишээлбэл, хуулийн чиглэлээр, байгаль орчны чиглэлээр хуулийн хэрэгжээгүй хэсэг, заалт гэхэд нэгдүгээрт Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 30.4, 31.8, 34.6, Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8.4.3, 8.4.4.

3.Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8.1, 8.5, 11.5, 27.5.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр хуулийн хэрэгжээгүй хэсэг, заалт дээр Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.2, 9.5. Энэ мэргэжил, салбарын улсууд энийг бүгдийг нь бичээд аваарай. Ажил хийсэн мөртөө тайлан ирүүлээгүй байвал одоо энэ жилийн эцсийн тайлан дээр ирүүлээд он гараад бас хэлэлцэгдэнэ шүү дээ энэ чинь.

Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20.6, 23.4.

6 дугаарт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 14.2, Малын генетикийн нөөцийн тухай хуулийн 13.4, 8-д Хоршооны тухай хууль шинэчилсэн найруулгын 43.2.1. Энэ хуулийн чиглэлээр.

Хоёрт, Улсын Их Хурлын тогтоол

Байгаль орчны чиглэлээр улсын тогтоолын хэрэгжиж буй хэсэг, заалт гэнэ.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

1.Зарим газар нутгийн улсын тусгай хамгаалалтад авах тухай 19 оны 5 сарын 2-ны өдрийн 41 дүгээр тогтоолын 4 дэх заалт.

2-т. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 21 оны 12 сарын 30-ны өдрийн 104 дүгээр тогтоол.

Генетикийн нөөцийн тухай. Энэний 1.2 дахь заалт.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээрх улсынх нь тогтоолын хэрэгжээгүй заалт.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаарх авах зарим арга хэмжээний тухай” 22 оны 6 сарын 7-ны өдрийн 36 дугаар тогтоол. Энд олон заалт байгаа.

5 дахь нь “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 23 оны 12 сарын 7-ны өдрийн 107 дугаар тогтоол.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль баталсантай холбогдуулан энд 1.1, 1.2, 1.3, 1.5, 1.6, 1.7 дугаар заалт.

Мөн 6 дугаарт, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 24 оны 4 сарын 19-ний өдрийн 31 дүгээр тогтоол.

Гаалийн албан татварыг чөлөөлөх тухай. Энэ 4 заалт байгаа.

7 дугаарт, “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 24 оны 6 сарын 5-ны өдрийн 63 дугаар тогтоол. Энд бас олон заалт байгаа.

8-д, “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 17 оны 12 сарын 14-ний өдрийн 82 дугаар тогтоол.

Малын генетикийн нөөцийн тухай хууль. Энэ 1.3 дугаар заалт нь байгаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоол байгаа. Байгаль орчны чиглэлээрх Байнгын хорооны тогтоол хэрэгжээгүй заалт гэж байна.

1.“Чиглэл өгөх тухай” 18 оны 5 сарын 16-ны өдрийн 6 дугаар тогтоол.

2-т, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2019 оны 5 сарын 28-ны өдрийн 04/01 дүгээр тогтоол. Энэний 1.1 дэх заалт.

3.“Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 22 оны 5 сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоол. Энэ олон заалт бүх заалтыг хараарай.

4.“Тусгай хамгаалалттай газар, нутгийн хилийн цехийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 23 оны 1 сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоол. Энд 4 заалт байна.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээрх Байнгын хорооны тогтоолын хэрэгжингээ заалт гэж байна. “Чиглэл өгөх тухай” 20 оны 5 сарын 6-ны өдрийн 6 дугаар тогтоол.

“Чиглэл өгөх тухай” 20 оны 12 сарын 16-ны өдрийн 10 дугаар тогтоол. 1, 2, 5, 6 дугаар заалт юм байна.

7.“Чиглэл өгөх тухай” 21 оны 2 сарын 26-ны өдрийн 7 дугаар тогтоолын 2.1 дүгээр заалт.

8-д, “Чиглэл өгөх тухай” 22 оны 1 сарын 17-ны өдрийн 01 дүгээр тогтоол. Энэний 1.1, 1.3, 1.4, 1.5-1.19 хүртэлх заалт.

9.“Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад зарим арга хэмжээний тухай” 22 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 04 дүгээр тогтоол.

10.“Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 23 оны 1 сарын 17-ны өдөр 02 дугаар тогтоол.

Агаарын бохирдлыг бууруулах асуудлаар дэд хорооны тогтоол байгаа юм байна. “Чиглэл өгөх тухай”, Агаарын бохирдлыг бууруулах асуудал дэд хороо 16 оны 2 сарын 3-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 1.2 дахь заалт гэх мэт олон тогтоолын биелэлт нь ерөөсөө биелэгдэхгүй байгаа. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар сая 130 орон тоотой гэл үү? Энд хяналт тавьж, засгийн ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Тийм учраас энэ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаа ямар шалтгаантай байна? Цаашид хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авах вэ? Салбарын сайдууд, Төрийн нарийн тодорхой хариул даа.

Энхбаяр сайд хариулья.

**Б.Энхбаяр:** Энэ Улсын Их Хурал баталсан хууль тогтоомжийнхоо хэрэгжилтийг байнга хянаж байх ёстой. Тэгж байж энэ баталсан хууль тогтоомж маань яг салбарыг зохицуулж чадаж байна уу, Монгол улсын яг нийгэм, эдийн засгийн амьдралыг үйлчилж байна уу гэдгээ харж байх ёстой гол эргэх холбоо нь энэ. Нэг онцлог сая үүсээд байгаа юм. Мэргэжлийн хяналтын газар гэж мэргэшсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байсан том агентлагийг татан буулгаж, бүх хяналтыг салбаруудад өгсөн. Хэрэг эрхлэх газар улсын хэмжээний хяналтыг нэгтгэн зохион байгуулах гэж оролдож байна. Дөнгөж жил гаруй, 2 жил болох гэж байна. Тэгэхээр энэ дээр бид нар дүгнэлт хийх хэрэгтэй байгаа юм.

Нөгөө талаас хяналтад шаардлагагүй 1300 гаруй хяналтын заалт, чиглэлүүд үүсчихсэн. Энийг хасах ёстой гэж байгаа юм. Тэгэхээр энэ бид анхныхаа тайлангуудаа оруулж ирж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ дахин үүрэгжүүлээд энэ Хэрэг эрхлэх газрын Хяналтынх нь бүүр деталиар нь задалмаар байгаа юм. Жишээлбэл манай яаман дээр энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой энэ заалтууд 49, тайлан гаргах ёстой заалтаас 47 нь хэрэгжээгүй гэж гарч ирсэн байгаа юм.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Гэтэл манайд хамгийн сайн хэрэгжсэн, хамгийн олон үйлдвэр ашиглалтад орсон, хамгийн олон стандарт нэвтэрсэн, хамгийн олон үйлдвэр, үйлчилгээ, бүтээгдэхүүн бий болсон ажил байгаад байгаа байхгүй юу. Мал аж ахуй, мал, махны экспорттой холбоотой 5 заалт 5-уулаа биелээгүй гэж байгаа юм. Гэтэл бид нар сүүлийн 3 жил Монгол Улсын экспортыг 300 сая доллароос буулгасангүй. Энэ чинь урьд нь 10, 20 сая доллароос хэтэрч үзээгүй. Махны экспорт чинь 300 сая доллар давдаг болчихоод байдаг. Дэлхийн 17 оронд бид нар стандарт, шаардлага хангаад экспортлоод байдаг. Улсын хэмжээний гоц халдварт өвчний голомтуудыг хумиад, цэгцлээд байгаад байдаг.

Тэгэхээр асуудал юундаа байна? Энийгээ ахиад бүр дахин задалж үзмээр байна. Эндээс тэгээд үнэхээр яг хариуцлага алдсан бол тэр хариуцлагыг нь хүргээд энийгээ ахиж дахин бүгдээрээ үүрэг өгөөд ажлын хэсэг гаргуулаад ахиж нүдээд бүр деталиараа гаргая. Ер нь цаашдаа Монгол Улс, Их Хурал хууль тогтоомжийнхоо хяналтыг хэрхэн хянаж байх ёстой вэ гэдэг юмаа бид нар арга зүйг ахиад олоод авъя. Өмнө энэ чинь Мэргэжлийн хяналтын байгууллага гээд энэ цогц хяналтууд бүх салбараа хамраад хийдэг байсан юм. Би өөрөө энэ Мэргэжлийн хяналтын газар яг энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн асуудлыг хариуцдаг байсан байхгүй юу. Ажиллаж байсан юм. Тэгээд тэнд цогц, тодорхой улсын хэмжээнд нэгдсэн бодлого гаргаж чаддаг байсан. Одоо бол нөгөө бодлогын гэж байгаа яамнууд дээрээ салбарын хяналтыг өгчихөөр бодлогын яамнууд гэсэн бүтэц дээр үйл ажиллагааны яам болоод хувирчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бодлого хийх, үйл ажиллагаа 2 хариуцах ийм төрийн яг системийг бид нар эргэж дүгнэх зайлшгүй бас үүгээр гаргамаар байгаа юм. Цаашдаа ер нь яах ёстой юм? Ингээд төрийн яамнууд үйл ажиллагааны яам болоод бодлогоо орхиод, бодлогоо гаргадаг, өөрөө хянадаг ийм чиглэл рүүгээ явах юм уу, эсвэл сая энэ чинь бид нар Шинэ Зеландын загвар гээд энэ чинь 2000 оны эхээр чинь манайх бүх яамандаа цомхотгоод, бодлогын болоод, үйл ажиллагаануудаа аж ахуйн ажлуудаа тусгаарлаад агентлаг гэдэг хэрэгжих энэ агентлагуудын бүтцийг бий болгоод энэ чинь том төрийн албаны шинэчлэл хийсэн байхгүй юу. Энэ дээр бас дүгнэлт хиймээр байгаа юм.

Сая бол Мэргэжлийн хяналтын газрыг татан буулгах туйлын хариуцлагагүй улс төрийн богино, маш дутуу бодож айхтар том өөрчлөлт хийчихсэн. Тэгээд үр дагавар нь ингэж гарч эхэлж байгаа юм. Бодлогын гэдэг цомхон бүтэцтэй яаман дээр чинь хяналт ороод ирчихсэн. Бид хаанаа яг хяналтыг хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал бас маш амаргүй байна. Ингээд салбарын хяналт шилжиж байна. Жишээлбэл, манайх гаалийн байгууллагаас, хилийн хорио цээрийн байгууллагаас энэ хяналтуудыг шилжүүлж авах, дагасан программ хангамжуудыг уялдуулах, хууль, эрх зүйн тогтоомж тэр дүрэм, журмыг шинэчлэх гээд бүр бөөн нүсэр түмэн ажлын дунд орчхож байгаа байхгүй юу. Ингэснээр нөгөө төрийн бодлогын систем өөрөө эвдэрч эхэлж байна. Өмнөх бодлого чинь, бүтэц чинь эвдэрч эхэлж байгаа байхгүй юу. Энэ дээр бас Их Хурал ингээд дүгнээд цаашдаа бид үйл ажиллагааны яамнуудаа байх юм уу, эсвэл бодлогын чиглэлээ барих ёстой юм уу гэдэг юм тодорхой болгох иймэрхүү маягаар дүгнэлт хийвэл их сайн байна.

**Б.Бейсен:** Байгаль орчны яамнаас 9 номер.

**Ш.Батбаяр:** Байгаль орчны яам Төрийн нарийн бичгийн даргын албыг түр орлон гүйцэтгэгч Батбаяр байна. Энэ Бейсен гишүүний асуусан асуулт дээр бас



2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хэд хэдэн бас хариулт өгье өө жишээ татаж. Энэ Хяналт хэрэгжүүлэх газрын тайлан, мэдээ дээр бас 1 асуудлыг бас хэд хэдэн удаа оруулсан хяналтаас хасах шаардлагатай асуудлууд хэд хэд давхцаж орсон бас үзүүлэлтүүд гарч байгаа. Үүний жишээ нь энэ “Тусгай хамгаалалттай газрын хилийн заагийг тогтоох тухай” энэ Улсын Их Хурлын 41, 46 дугаар тогтоол нийт 31 газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авч тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөтгөсөн байгаа. Энэ хүрээнд манай яамнаас холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн байгалийн нөөц болон дурсгалт газрын нийт 19 газрын хил, заагийг тогтоож улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээ нь өнөөдрийн байдлаар 1498000 га талбай буюу 0.8 хувиар нэмэгдэж, манай улсын 2035.../минут дуусав./

**Б.Бейсен:** Энэ хуулийн хэрэгжилтийн асуудал дээр би урьд 4 жил бас энэ ажлын хэсэг дээр ороод ажилласан. Мал, махны экспортын ажил, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийн асуудал. Гэтэл сая Энхбаяр сайд чинь ярьж байна. Ер нь салбарын агентлаг, газар, хэлтсийн дарга нар тайлан өгөөгүй, ирүүлээгүй гэсэн ийм асуудал үүсэж байгаа байхгүй юу. Хийсэн ажил нь байгааг мэдэж байгаа юм чинь. Тэгсэн мөртөө хэрэгжилтгүй, тайлан өгөөгүй гэдгээр ингээд тусгаад явчихдаг. Салбарын сайдууд энэ улсууддаа бас хариуцлага тооцох юм уу? Энийг эрчимжүүлэхгүй бол үнэхээр болохгүй нь ээ. Бямбацогт сайд бас энэ анхаарч ажиллах байх гэж бодож байна. Энэ үнэхээр салбарын тийм улсуудын хариуцлагагүй байдал.

Нөгөө талаар энэ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар энэ дээр онцгой анхаараад шаардлага тавьж байхгүй бол болохгүй нь. Бид бас Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газартаа бас энийг эрчимжүүлээд он гарсны дараа жилийн эцсийн тайлан дээр бас онцгой анхаарч ажилла гэдгийг хэлье. Төрийн ажил тасралтгүй явагдах ёстой. Иймээс онцгой анхаарч ажиллаарай гэдгийг хэлье.

Гишүүд асуулт асууж, дууслаа. Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Мөнхсоёл гишүүнээр тасалъя. Мөнхсоёл гишүүн үг хэлье. Одонтуяаб Гишүүний ирцээр нь орсон байна. Одонтуяа гишүүн үг хэлье.

**С.Одонтуяа:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр бас энэ салбарт 1 жил гаруй хугацаанд бас сайдаар ажиллаж байсны хувьд энэ салбарын зовлон, жаргалыг нэлээд мэдэж байгаа, ойлгож байгаа. Асуудлууд байгаа юу гэвэл байгаа. Тэгэхээр би ер нь зөвхөн манай яам биш болов уу сая бас Энхбаяр сайд ч хэлж байна. Манай энэ яамнууд чинь ерөөсөө нөгөө бодлого гаргах яамнаасаа бүр үйл ажиллагаанаасаа их холдчихсон юм билээ. Бодолго хийх ямар ч цаг зав тэр яамныханд үлдээгүй. Бүх ажил нь дандаа хэрэгжүүлэх асуудлыг хийдэг ийм завгүй яамнууд болгочихсон юм байна лээ. Энэ дээр жишээлэхэд төр дандаа ингээд ерөөсөө би л бүгдийг нь хийнэ гээд л өөрсөд дээрээ овоолоод байдаг.

Гэтэл төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулаад эрхийг нь өгье гэхээр бүх юм хаалттай байна. Нөгөө гараараа ерөөсөө ТББ, хувийн хэвшил, мэргэжлийн нэгдсэн холбоодод аль болохоор л эрх мэдлийг нь шилжүүлье гэхээр энийг хуулиар бүгдийг нь ингээд зогсоож боомилсон байна. Тийм учраас энэ асуудлыг шийдэж энэ хэрэгжүүлдэг зарим чиг үүргийг тэр холбоод руу нь өгөх ёстой. Жишээлэхэд усны тусгай зөвшөөрөл тэр тусгай хэрэг зөвшөөрөлтэй компанийг

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шалгаруулах ч гэдэг юм уу тэрийг сайд мэдэхгүй л байхгүй юу. Тэрийг чинь мэргэжлийн холбоод нь шалгаад ингээд тэр мэргэжлийн сертификатыг нь өгдөг юмыг нь бид нар зоригтой өгөхгүй юм байна лээ.

Яагаад ингээд энэ дээр гацдаг юм гэхээр ерөөсөө Монгол Улсын ТББ л баяжчих гээд байгаа юм шиг л бүүр ийм хартай сэртэй. Бүүр энэ бодвол нөгөө социализмын хөлсөө ингээд үлдчихсэн юм болов уу. Нэг хувийн хэвшилд гэрээгээр ингээд юм ажиллуулъя бараг зардал гарахгүй төсвөөс зардал гарахгүй гэхэд л ерөөсөө бүх юм нь ингээд хаалттай ийм байж байх шиг. Тэгэхээр энэ хүмүүс ерөөсөө энэ хэрэгжүүлэгч ажлаа хийгээд чаддаггүй юм байна лээ шүү. Энийг би бас хэлчихмээр байна.

Хоёрдугаарт, энэ Одбаяр сайдын хувьд процессыг нь дахин инженерчлэл гэж хийгээд, тэр ажилчдаас нь асуултууд асуугаад, бүх энэ салбараас асуугаад ийм чухал мэдээлэл манай дээр дүгнэлт хийж өгсөн. Энийг бид нар бас хэрэгжүүлэх гэж оролдох ёстой юм байна лээ. Энэ бодлого хэрэгжилт хоёрыг ингээд салгасан ийм их чухал зүйл байсан гэдгийг хэлмээр байна. Тэгээд Бямбацогт сайдад бас хэлмээр байна. Ер нь бид нар энэ гаднын туршлагыг аваад жоохон хөнгөвчлөхгүй бол өнөөдөр зөвхөн манай салбар биш эмч нар энэ тайлангаа явуулах гэж хамаг цагаа бардаг. Нөгөө хүнээ үзэхийн оронд л ерөөсөө цаастай, компьютертой зууралдаад л. Ингээд л тайлан өгдөг л ажилтай. Тэр ажлын 5 өдрийн хэдэн өдөр нь тэр тайланг бичдэг юм ёстой үнэхээр бүүр хэтэрхий ийм хүнд сурталтай болгоод хаячихсан юм билээ.

Тэгээд л тусгай хамгаалалттай газар нутаг гэхэд манай яаманд 6-7 хүн ингээд л ажиллалаа гэхэд тэр хүмүүс бодлого хийх ямар ч цаг байхгүй. Ерөөсөө л дандаа хэрэгжүүлэх юм хийдэг. Тэгээд яг менежмент хийе гэхээр хүн, хүч байхгүй, хөрөнгө байхгүй. Тэгээд энэ засаг төр чинь ерөөсөө бүх л төсөв хөрөнгийг нь хасчхаад, бүх юмыг нь хасчхаад бас яаж энэ хүмүүсийг ингээд ажил гэдэг юм. Би энэ дээр маш тийм шүүмжлэлтэй хандмаар байдаг. Энийг өөрчлөх ёстой шүү. Зүгээр нэг нь ирээд худлаа хянасан болоод яам, тамгынханд тайлан өгөх гээд энэ үнэхээр боломжгүй байгаа бол энийг өөрчилье л дөө. Тэр хүмүүсийг чинь би өдөр, шөнөгүй ажиллаж байгааг нь мэднэ шүү дээ. Тэгээд дандаа хэрэгжүүлэх юмаар ингээд шахчихсан.

Жишээлэхэд Байгаль орчны үнэлгээний хурал гээд л манай яаман дээр байнга өдөр болгон л хуралдах юм. Тэгээд нэг жижигхэн лабораторид зөвшөөрөл өгөхийн төлөө л тэнд үнэлгээ хийнэ гээд л хүмүүсийг чирэгдүүлээд л 20, 30 юм нэхээд л ингээд л байж байгаа. Тэгэхээр яах вэ Бат-Эрдэнэ сайдын үед энэ цахимжилтыг нэлээд бас нэвтрүүлсэн учраас харьцангуй арай бас ажил хөнгөвчилсэн. Тэгэхээр ер нь Монгол хүн Монгол хүнээ махалдаг төрийн албан хаагчдыг маш.../минут дуусав./

**Б.Бейсен:** Мөнхсоёл гишүүн үг хэлье.

**Б.Мөнхсоёл:** Ер нь энэ хяналт шинжилгээ, үнэлгээний ажил нэлээн чанаргүй хайран цаг гэж бодмоор байгаад байгаа. Энэ өөр Байнгын хороодод ч гэсэн адилхан ийм асуудал яригдсан юм. Тэр ч утгаараа үнэлгээ, мониторингийн ажлын хэсэг гэж үүссэн. Сая та нар анзаарсан бол ирэх оны Төсвийн тухай хууль хэлэлцэж байх үед 10 гаруй хуудас, 40 зарчмын зөрүүтэй санал оруулж байгаад 260-аад ийм үнэлгээ хийх тэр шалгуур үзүүлэлтүүд, мониторинг хийх тэр шалгуур

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үзүүлэлтүүдийг өөрчилсөн шүү. Саналаа оруулсан 16 гишүүд ажиллаад. Тэр бас их нэмэр болох байх гэж бодож байна.

Яагаад вэ гэхээр энэ үнэлгээ чинь аягүй субъектив байгаад байна. Тэр учраас дарга үнэлбэл нэг өөр ч гэдэг юм уу, эсвэл тухайн хэлтэс, газрын даргыг үнэлбэл нэг өөр, тухайн байгууллага өөр өөр байгууллагууд үнэлэхээр өөр энэ тэр гарчхаад байна шүү дээ. Тэгэхээр нөгөө үнэлж байгаа үнэлгээний тэр хэмжээс чинь хүнээс хамаараад байна. Хэн хэнтэй ямар, хэр мэддэг юм, хэр мэддэггүй юм гэдэг хүртэл орчихдог юм байна шүү дээ. Түрүүн 2 сайд өөрсдөө хэлж байна шүү дээ бас. Тэгэхээр нэгдүгээрт энэ арга, методологийн асуудал байна. Методологи дээрээ эргэж ажиллах ёстой юм байна. Арга зүйн асуудал дээрээ.

Хоёрдугаарт, энэ хүн хүчний асуудал байна. Хүн хүч. Би бүүр ингээд санаа зовоод хэд хэдэн удаа бас хэлсэн. Энэ төрийн албан хаагчдыг Одонтуяа гишүүн ч бас хэлж байна. Ажлаа хэзээ нь хийдэг юм бол гэж бүүр санаа зовмоор энд авчирч болсон, болоогүй нэг нь асууж нөгөө нь хариулсан байдалтай. Тэгэхээр яг энэ цомхон хэдэн гол хүмүүсээ авчраад л сайд нь өөрөө цуг сууж байгаад л хариулдаг баймаар байгаа байхгүй юу. Нээх их олон нүргэлсэн олон хүн авчраад л ёстой асуусан ч юмгүй, хариулсан ч юмгүй хайран цаг. Ёстой энэ дээр Монголчууд бид нар бие биеийгээ хуурч байна гэж ний нуугүй боддог шүү.

Гуравдугаарт, тэр хууль, эрх зүйн орчин дээр ажиллах ёстой юм байна шүү дээ. Сая Энхбаяр сайд бас хэлж байна шүү дээ. Одоо Мэргэжлийн хяналт гэхэд л болсон, болоогүй тэр олон хяналт хийгддэг. Дээр үеэс л яригддаг байсан шүү дээ дээ. Стандартыг өөрчилье. Уг нь Их Хурал дээр ажлын хэсэг Стандартчиллын ажлын хэсэг үүссэн. Тэгээд бас дорвитой юм болсон уу, үгүй юү? Тэгээд ийм бид нар хүчээ тарамдаад байна гэдгийг л хаа сайгүй хэлэх гэсэн юм. Хүчээ тарамдаад байна.

Тэгэхээр Бямбацогт сайд, Хэрэг эрхлэхийн сайд маань энэ энэ миний сая та нарыг сонсоод базаж хэлж байгаа 3 юм шүү. Методологи, арга зүй, хоёрдугаар нь хүн хүч, хүний тоо болон чанар, чадамж, цаг хугацаа гэсэн үг шүү дээ. Гуравд нь хууль, эрх зүйн орчин дээр ажиллахаас өөр аргагүй юм байна. Оновчтой болго. Үгүй бол ингэж хянасан болоод хайран баахан цаг зараад тайлан гаргаад тэр нь ярилцаад үр дүнгүй болчихоод байгаа нь бүүр үнэхээрийн харамсалтай хайран санагдаад байгаа юм. Тэгээд тэр субъектив байдлыг багасгах хэрэгтэй л юм байна. Амжилт хүсье.

**Б.Бейсен:** Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Би бас зарим юмыг жоохон гайхаад байна. Хяналт хэрэгжүүлэх газар жишээлбэл энэ Засгийн газарт үүрэг, чиглэл болгосон тус Байнгын хорооны 11 тогтоол тус бүрийн биелэлтийг авч үзүүл гээд “Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 2023 оны 1 сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолын 6 заалтын биелэлт 28.3 хувь буюу хэрэгжилт хангалтгүй байна гээд. Тэгээд би энийг ойлгохгүй байна. Энэ болчихсон шүү дээ. 100 хувь болсон. Яагаад 2023 онд Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засан даргыг Тамгын газар нийлж байгаад Нисэх, Яармаг орчмын Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийг 2012 онд хууль бусаар өөрчилснийг буцаагаад хэвд нь оруул гэдэг шийдвэрийг гаргаад Байнгын



2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хорооны тогтоол хэрэгжчихсэн. Энд яагаад 100 хувь болсон ажил 28.3 хувьтай байгааг би ойлгохгүй байна жишээлбэл. Миний үеийн ажил. Үүнээс чинь болж 80 гаран аж ахуйн нэгж, иргэний газрыг цуцлаад нийслэлд шилжүүлээд тэн дээр бөөн юм болсон байхгүй юу. Энэ 100 хувь.

Хоёрдугаарт, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2022 оны 5 сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолын 13 заалтын биелэлт 30 хувьтай буюу хэрэгжилт хангалтгүй. Энэ юунаас болсон гээч? Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг Засгийн газраар оруулаад явуулах гэсэн чинь Газрын хуулиа оруулж байж Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиа орууллаа гээд хойшлуулчихсан байхгүй юу. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам өнөөдрийнхөөр ингээд манай хөөрхий хэдэн төрийн албан хаагчид маань сууж байна л даа. Батбаяр сайн ажиллаж байгаа. Оюунсанаа сайн ажиллаж байгаа. Энэ муу Уранчимэг хөөрхий чөмгөө дундартал гэдэг шиг ажиллаж байгаа байх. Тэр хуучин Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаад одоо Цаг уур дээр байгаа манай Баттулга байна, Энхмөнх байна, Буяннэмэх байна. Энэ хүмүүс Байгаль орчны яаман дээр өнөөдрийг хүртэл байж байгаа учир шалтгаан бол энэ хүмүүс сайн ажилладаг юм. Энэ хүмүүсийн үнэлгээг та нар Байнгын хороон дээр оруулж ирэхдээ ингэж унагааж болохгүй. Энэ бодит нөхцөл байдал. Засгийн газраас шалтгаантайгаар асуудал нь хойшилсон зүйлийг яамны ажилтан, мэргэжилтэн, яамны алдаа юм шиг хэрэгжилт хангалтгүй гэж оруулж ирээд хариуцлага тооцох асуудал хөндөгдөж болохгүй. Энэ зарчмын асуудал. Энийг та нар ялгаж, салгах ёстой.

Батцэцэг дарга түрүүнээс хойш би уул нь асуулт асуусан. Ярьж байгаа зүйл нь үнэлгээ бид нар яаж хийдэг вэ гэдэг тухайгаа яриад байгаа юм. Би таныг үнэлгээ яаж хийдэг тухай чинь ерөөсөө асуугаагүй. Та нар энэ үнэлгээ хийгээд явж байх процесс дээр алдаатай үнэлгээ чинь танайх дээр өөр дээр чинь байгаад байна. Өөр дээр чинь байгаад байна. Тийм учраас та нар хүн хүч чинь хүрч байгаа юм уу, санхүүжилт чинь болж байгаа юм уу, танай чадамж байгаа юм уу гэж би асуугаад байсан утга нь тэр. Та нар өөрсдөө хангалтгүй байна.

**Б.Бейсен:** Ганхүлэг гишүүн үг хэлье.

**М.Ганхүлэг:** Хагас жилийн Улсын Их Хурал, Байнгын хороогоор гарсан хууль тогтоомжууд дээр үнэлгээ хийгээд өнөөдөр бас Байнгын хороогоор хэлэлцэж байна. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хууль тогтоомжийн хэрэгжилт 45.8 хувьтай хэрэгжсэн байна гэсэн дүгнэлтийг танилцуулж байгаа юм байна. Яах вэ энгийнээр хэлэх юм бол “F” авч байна гэсэн үг л болж байна л даа. Тийм тэгээд хэд хэдэн бас тодорхой саналууд хэлье. Юуны өмнө бас манай Байнгын хороо тодорхой асуудал хариуцсан сайдууддаа хариуцлага тооцох эрх зүйн боломж ямар хэлбэрээр байдаг вэ гэдэг дээр бид нар бас бодох ёстой байх. Үнэхээр ийм тодорхой чиглэл хариуцсан сайдууд гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдолд бид ер нь цаашдаа яаж явах вэ, толгойг нь илээд ингээд байх уу гэдэг тухай асуудал эхний асуудал хөндөгдөж байна. Хэрвээ энэ дээрээ бид нар тодорхой арга хэмжээ авахгүй бол энэ байдал ингээд үргэлжилсээр л байх болно.

Хоёрт нь би гишүүдийн хэлж байгаа энэ шалгуур үзүүлэлттэй холбогдолтой асуудлыг ер нь дараагийн үнэлгээ юмнууд гарах тэр хугацаа хүртэлх нь бас

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нэлээн нарийвчилж гаргаж ирэх нь зөв өө гэж бодож байна. Энэ тухай бас Их Хурлын гишүүд ч гэсэндээ нэлээн яриад байгаа. Ядаж л бид тог цахилгаанаа километрээр хэмжихгүй байхаас эхлэх ёстой байна. Яг ямар үр дүнд хүрсэн байх ёстой вэ гэдэг тэр үр дүн нь тодорхой байж байж, тэр шалгуур нь тодорхой байж байж үүнийг хэмжих энэ байдал нь илүү бас сайжирна. Тийм учраас энэ дээр болохгүй байгаа асуудлуудаа нэлээн сууриар нь хараад задлаад Энхбаяр сайдын хэлж байгаа тэр нарийвчилсан ажлын хэсэг юмнуудыг байгуулаад ажиллах гэдэг саналтай санал нэг байна гэдгээ бас хэлье.

Ингээд тодорхой дүгнэлтүүд ингээд гарч байгаа юм байна. Үүнийгээ Засгийн газрын хурал дээр, олон нийтэд тухайн бас асуудал хариуцсан сайд нараар нь хэрэгжилтийн нөхцөл байдлыг нь ил тодоор зарлах, олон нийтэд хүргэх. Иргэд тухайн бас мэдээллийг авч шаардлага тавих энэ боломж бололцоог бас илүү сайжруулж ажиллах бас хэрэгтэй байна. Аль нэгэн өөр өөрсдийнхөө ажлыг бас хаацайлах гэхээсээ илүүтэй тодорхой энэ ажил, үйл ажиллагааг цаашдаа илүү сайжруулах чиглэлийн хүрээнд ил тод байдал, нөгөө цахим шилжилтийн энэ асуудлуудыг бас илүү сайжруулах чиглэл дээр бас анхаарах нь зөв байна гэсэн тодорхой ийм 3 саналыг хэлье.

Бидний байгаа яах вэ нөхцөл байдал яг үндсэндээ яг ийм байдалтай бас байгаа. Зөвхөн Засгийн газар төрийн албан хаагчдад биш, шийдвэр гаргаж байгаа бидэнд ч асуудал бас байна. Төрийн албан хаагчдын маань хувьд бас ер нь яамдын ажлуудын дийлэнх хэсгийг нь хариуцаад явдаг цөөхөн хэдхэн бүх ажлыг нугалж байдаг хүмүүс бас байж байдаг. Түүний цаана нь эс үйлдхүй хийгээд бас байж байдаг хүмүүс бас байдаг. Хийсэн ч ялгаагүй, хийгээгүй ч ялгаагүй ийм нөхцөл байдлууд үндсэндээ байгаад байдаг учраас Монгол Улсын одоогийн ингээд бүтээмж бүрэн хүчин чадлаараа бас ажиллаж чадахгүй байгаа юм. Бидний тэр бүтээмжийг нь үнэлж байгаа энэ шалгуур үзүүлэлтүүд, энэ процессууд, хариуцлага тооцож байгаа энэ байдлууд шударга бус, ил тод бус байгаа учраас нийт энэ бас ажилтад, ажилтан албан хаагчдынхаа потенциалыг бид нар бас бүтэн ашиглаж чадахгүй байгаа юм. Аливаа ажил санаачлаад янз бүрийн юм хийхээр эсрэгээрээ асуудалд ордог учраас хийхгүй байх нь дээр байх хувилбар луу хүртэл бас дийлэнх массаараа бид бүхэн бас орчхоод байдаг ийм нөхцөл байдлууд бас байдаг.

Тэгэхээр энэ асуудлуудыг нэлээн сууриар нь авч үзэх, зөвхөн ингээд яриад дуусахгүй байх талаас нь бас Байнгын хорооны дүгнэлт, саналууд нь гараад ажлын хэсэг юмнууд бас гарвал идэвхтэй ажиллаад явъя гэсэн ийм саналтай байна.

**Б.Бейсен:** Бямбацогт сайд үг хэлье.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Гишүүдийнхээ сая бас хэлсэн саналуудыг, мөн бас тавьж байгаа шүүмжлэлүүдийг бид нар бас анхааралтай сонслоо. Тэгээд бүгдийг нь бас манай холбогдох албан тушаалтнууд тэмдэглэж авсан. Засах, залруулах, сайжруулах зүйлүүд олон байгаа. Мөн бас хариуцлагагүй ажиллаж байгаа, бас алдаа дутагдал гаргасан зүйлүүд бас мэр сэр байгаа байх. Энийг цааш цаашдаа бид нар засаад үндсэндээ энэ хагас жилийн тайлангийн мэдээллийг та бүхэндээ бас Их Хуралд танилцуулж байгаа.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхээр бүтэн жилийнхээ мэдээллийг гүйцэтгэлийнхээ тайланг ирэх онд бас тавина. Ирэх оны 1 дүгээр улиралд. Тэр үедээ сая яригдсан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт шинжилгээ хийж, үнэлгээ, дүгнэлт өгч байгаа. Энэ дээр бас гарч байгаа асуудлуудыг бүгдийг нь засаад залруулаад иймэрхүү асуудлууд гаргахгүй оруулах талд бид анхааръя гэдгийг нэгдүгээрт нь хэлье.

Ер нь хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй гэж үг байдаг. Тийм болохоор бид нар маш сайн төлөвлөдөг. Төлөвлөснөө сайн гүйцэтгэдэг байж байж сайн үр дүн гарна. Сайн төлөвлөлттэй, муу гүйцэтгэлтэй байвал муу үр дүн гарна. Муу төлөвлөлттэй, сайн гүйцэтгэлтэй байвал бас үр дүн гарахгүй. Тийм болохоор хаана хаанаа төлөвлөлтөөсөө авхуулаад зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих энэ бүх процесс дээрээ маш сайн л бүгд ажилладаг байх хэрэгтэй байгаад байгаа юм.

Улсын Их Хурал бол төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага, бодлого тодорхойлдог. Засгийн газар бол гүйцэтгэх дээд байгууллага. Бодлогыг хэрэгжүүлдэг. Тийм болохоор энэ дээр бид нар бас бодлогыг хэрэгжүүлэх тал дээр бас хэд хэдэн асуудлууд байна. Энийг бас анхааралдаа аваад бас манай Байнгын хороо хэрвээ ажлын хэсэг байгуулах бол энийг бас анхааралдаа аваасай гэж хүсэж байгаа юм.

Энэ Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль тогтоомжийн биелэлтэд, хэрэгжилтэд 5 жилд 1 удаа бас хяналт тавьж, үр дүнг нь үнэлгээ, дүгнэлт өгнө өө гэсэн заалт байдаг. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд болохоор ингээд хагас жил тутамд үнэлгээ хийдэг. Хагас жил, бүтэн жилээр үнэлгээ хийнэ гээд ингэчихсэн. Энэ 2 хуулийн зөрчил байгаад байгаа юм. Бүхэл бүтэн том бодлогын хуулийг хагас жилээр хэрэгжсэн, хэрэгжээгүй гэж үнэлж дүгнэх бас учир дутагдалтай. Энэ бас сул талаа бид нар яаж арилгах юм энийг бас анхаармаар байгаа юм.

Сая бас Энхбаяр сайд ярьж байна, Бат-Эрдэнэ гишүүн бас ярьж байна, Ганхүлэг гишүүн ч бас ярьж байгаа. Энэ Монгол Улсын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хаагдаж хязгаарлагдаж байгаа. Мэргэжлийн хяналт гээд салбарын хяналтыг багцлаад тавьдаг байгууллага байсан. Энэ байгууллага татан буугдсан. Үүнтэй холбоотойгоор үндсэндээ хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн аюулгүй байдал, барилга, уул уурхай гээд бүхий л салбарт бас нэлээн салбарын хяналтууд яамнуудаа очсон. Үүнтэй холбоотой өөрөө бодлогоо төлөвлөөд өөрөө өөртөө хяналтаа тавиад явдаг нь үндсэндээ хяналтыг их маш их сулруулж энэ Үндсэн хуулиар хүнд олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх ийм эрсдэл үүсэж байгаа. Энийг бас хэрхэн яаж цаашид шийдвэрлэх вэ гэдэг дээр та бүхэн бас анхааралдаа аваасай. Энэ бас нэлээн том том бодлогын асуудал.

**Б.Бейсен:** Гишүүд үг хэлж дууслаа. Ер нь Улсын Их Хурлаас гарсан хууль тогтоомж, чиглэлүүд, Засгийн газарт өгсөн чиглэлүүдийг харж байхад сая тайлан жаахан буруу байна гээд сая Бат-Эрдэнэ сайд ч ярьж байна, Хөдөө аж ахуйн сайд ч ярьж байна. Хийсэн ажлыг ерөөсөө дутуу мэдээлэлтэйгээ дутуу, буруу тайлан гаргадаг. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй. Нөгөө талаар бид бас Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээний газартай бас ярина. Үүний нэг бодит жишээ би өнгөрсөн 4 жилд махны экспортын

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

талаар ажилласан. Ганболд гишүүнээр ахлуулж ажилласан. 4, 5-уулаа ажилласан, танай Хөдөө аж ахуйн яамныхантай хамтарч яваад бүх газрыг нь үзсэн. Байгаль орчны энэ тусгай хамгаалалттай газрын чиглэлээр Батжаргал гишүүнээр ахлуулаад бид нар 3, 4 удаа яваа, танай яамныхан бүгд яваад үзсэн.

Гэтэл тайлан дээр нь энэ хууль тогтоомжийн хэрэгжилт, биелэлт дээр нь огт тусгадаггүй. Яамдад очсон юман дээр чинь яамны хяналт шалгалт, үнэлгээ газар гэж байна. Нөгөө талаар төрийн нарийнууд энэ дээр хяналт шалгалт хийгээд энэ тогтоолын биелэлт дээр тайлан зөвөөр нь өгч байх хэрэгтэй. Засгийн газар энэ хяналт хэрэгжүүлэх газар ч гэсэн энэ дээр очсон юман дээр чинь бид нар ихэнхдээ Ерөнхий сайд юм уу, салбарын юунд чиглэл өгч байгаа. Энийг бүгдийг нь бүртгээд тодорхой хариу хэрэгжүүлэх газар. Хийгээгүй ажил биш хийж байгаа ажлыг ингээд дутуу үнэлээд, буруу мэдээлэл өгөөд аль эсвэл өгөхгүй энэ яг салбарын тухайн хариуцаж байгаа албан тушаалтнуудын буруу гэж үзэж байгаа. Бид Байнгын хорооноос бас энэ талаар Засгийн газарт чиглэл өгнө. Яамдын сайдуудад бас хариуцлага тооцох чиглэл өгнө гэдгээ хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Гишүүд үг хэлж дууслаа.

Хууль тогтоомжоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа гэж хэлье. Дараагийн асуудалд оръё.

17.40 цаг

### **Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай”**

Өмнөх долоо хоногийн Байнгын хорооны хуралдаанаар Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын 17 дугаар Бага хурал COP-17-г зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хорооны дарга бөгөөд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонссонтой холбоотойгоор Байнгын хорооны гишүүдээс ажлын хэсэг байгуулах тодорхой асуудлаар COP-17 хурлыг зохион байгуулах Үндэсний хороонд үүрэг, чиглэл өгөх нь зүйтэй гэж үзсэн учраас Байнгын хорооноос ажлын хэсэг байгуулахаар санал оруулж байна.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол “Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6, 22.3.13 дахь заалтыг үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос тогтоох нь:

1.Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар Бага хурал COP-17-г зохион байгуулалтын талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар сонссонтой холбогдуулан тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөх, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ажлын хэсгийн ахлагчаар Бат-Өлзийн Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын гишүүн. Гишүүдэд М.Ганхүлэг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Ж.Золжаргал Монгол Улсын Их Хурлын гишүүн, Л.Мөнхбаясгалан Монгол Улсын Их Хурлын гишүүн, С.Одонтуяа Монгол Улсын Их Хурлын гишүүн, У.Отгонбаяр Монгол Улсын Их Хурлын гишүүн, А.Ундраа Монгол Улсын Их Хурлын гишүүн, Мөнхбаясгалан гишүүн нар, Уянгаа гишүүн, Золжаргал гишүүнийг нэмж оруулъя саналаар нь.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтны тухай өөр татан оролцуулах ажлын хэсэг Бат-Өлзийн Бат-Эрдэнэд зөвшөөрсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Мөнхбаясгалан гишүүн санал гаргах хэвээрээ юу гэсэн. Золжаргал гишүүн, Уянгаа гишүүнийг нэмж оруулъя. Бат-Эрдэнэ гишүүн тогтоолын төсөлтэй холбогдон асуулт асуух гэж байна. Үг хэлэх юм уу? Асуулт.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Уул нь өнгөрсөн долоо хоногт Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Үндэсний хороо бүгдийг нь дуудаад бид нар бас холбогдох асуултуудаа асуусан. Тодорхой хэмжээнд ажил хуучныг бодвол харьцангуй цэгцтэй явж эхэлж байгаа. Тэгэхдээ эхэлж байгаа шүү. Бид нар СОP-17 талуудын Бага хурал зохион байгуулах хүртэл бас цөөхөн хоног үлдсэн байна. Заавал ажлын хэсэг байгуулж явах шаардлага байгаа юу? Шууд өнгөрсөн долоо хоногийн гарсан асуулт, хариулт, дүгнэлттэй холбогдуулаад Байнгын хорооноос шууд тогтоолын төслөө боловсруулаад гишүүдээр хэлэлцүүлээд шууд үүрэгжүүлээд, хугацаатай үүрэг даалгавар өгөөд явчихвал болдоггүй юм уу? Заавал ажлын хэсэг гаргах ёстой юм уу гэдгийг би асуух гэж байгаа юм. Ажлаа хийж явж байгаа хүмүүсийг бас энд дуудаад дахиад баахан ажлыг нь алдагдуулаад ингээд юм болох вий дээ. Тэрийг хэлээд хариулаад өгөөч.

**Б.Бейсен:** Энэ СОP-17-гийн ажлын хэсгийнхэнтэй бас уулзаад санал авсан би. Тэгэхээр энэ чинь 10 мянган хүн хүлээж авна, хугацаа нь бас ойрдсон байна. Тийм учраас Байнгын хорооны гишүүд бас шалгаж яах биш ер нь зөвлөн туслах чиглэлээр энд тусалчихвал ер нь эрчимжүүлэх нь л ажил энэ чиглэлээр энэ ажлын хэсэг байгуулж байгаа л даа. Тэрийг гишүүд бас зөв л ойлгох шаардлагатай байна ер нь.

Мэндсайхан. Гишүүн.

**З.Мэндсайхан:** Би Бат-Эрдэнэ гишүүнтэй санал нэг байна. Энэ дээр ямар ч ажлын хэсэг байгуулах шаардлага байхгүй. Энэ чинь хариуцаад хийж байгаа Засгийн газар, хариуцсан сайд нь байж байхад бид нар тогтоолоор үүрэг өгөөд л тэрний дагуу явчихна шүү дээ. Тэгээд л Засгийн газрын ажил дээр энэ ажлын хэсэг чинь орж яах юм. Хажуугаас нь шахаж, дэмжиж явах юм уу? Ийм давхацсан юм хэрэггүй байх.

**Б.Бейсен:** Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Би саяынхтай сая хэлсэн ажил дээр ажил нэмж байгаа юм шиг шаардлагагүй гэж бодож байна. Байнгын хороо тогтоол гарах ёстой. Жишээлбэл, өчигдрөөс авхуулаад манай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд руу гадаад, дотоод явлаа гээд дайраад эхэлж байх шиг байна.



2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Үгүй одоо мөнгө босгохын тулд гадаад явна шүү дээ. Би энэ дээр Батбаатар сайдыг өмөөрнө. Зүгээр тэр цэцгийн дэлгүүрээр мөнгө авчихсан асуудал нь тусдаа асуудал байх. СОР-ын үйл ажиллагаа дээр мөнгө босгохын тулд салбарын сайд Монгол Улсаас мөнгө босгохгүй. Гадаадаас мөнгө босгоно.

Тэгэхээр төсөл, хөтөлбөрүүдээ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам очиж тэндээ юмаа ярина. Тэгэхээр Байнгын хороо энэ дээр тодорхой хэмжээний туслалцаа, дэмжлэгийг нь үзүүлээд тэр тогтоол дотроо албажуулаад, үүрэгжүүлээд, тодорхой хэмжээний бас тэр сайдыг, яамныхныг ажиллах бололцоогоор нь хангах шаардлагатай гэж харж байгаа юм.

Хоёрдугаарт, эзэнжүүлэх шаардлагатай маш олон ажлууд байгаа. Тэгэхээр өнгөрсөн долоо хоногт хаашдаа бид нар Байнгын хорооны хурал хийгээд тэн дээр холбогдох харьяа газрууд нь бүгд тайлан, мэдээлэл, явцаа танилцуулчихсан учраас эндээс яам, Үндэсний хороонд тодорхой хэмжээний үүрэг даалгавруудыг боловсруулаад л хугацаатай үүрэг даалгавар өгчих нь зөв л гэж би харж байна.

Тийм учраас Байнгын хорооны орж ирж байгаа энэ тогтоол хэрэггүй. Энийг татах саналтай байна. Ийм зарчмын, горимын саналтай байна.

**Б.Бейсен:** Тэгэхээр ийм байгаа л даа. Бид уг нь энэ ажлыг бас эрчимжүүлэх зорилгоор ажлын хэсэг байгуул гээд өнгөрсөн юунаас тогтоол гарга гээд ярьсан байхгүй юу. Тэгэхээр энэ тогтоолын юунд бас хяналт тавиад ажиллахыг манай Байнгын хорооны ажлаа албад, бас зөвлөхүүд, салбарын улсууд байна. Тэд нараар тогтоолын төсөлд хяналт тавиулья. Тэгээд энэ зарчмын зөрүүтэй санал гаргасан учраас санал хураалт явуулах уу? Горимын санал “ажлын хэсэг байгуулах шаардлагагүй” гэсэн санал гарч байна. Тэгээд санал хураалт. Санал хураалтад бэлдээрэй гишүүд. Санал хураалт.

Би дахиад уншаадахъя. Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын СОР-17 хурлыг зохион байгуулалтын талаарх мэдээллийг Байнгын хорооны хуралдаанаар сонссонтой холбогдуулан тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөх шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг дэмжье гэдэг санал байна. Нөгөө талаар санал гарсан учраас, гишүүдээс санал, горимын санал гарсан учраас энийг шаардлагагүй гэдгээр санал хураая.

Зөв шүү дээ. Шаардлагагүй гэдгээр санал хураах гээд байна шүү дээ. Бат-Эрдэнэ гишүүн санал гаргаж байна шүү дээ энэ чинь. Тийм. Санал хураалт.

Мэндсайхан гишүүн юм хэлэх гээд байгаа юм уу? Ганхүлэг гишүүн.

Энэ тогтоолын ажлын хэсэг байгуулья гээд энэ тогтоолын төсөл дэмжигдэж байна. Тэрүүгээр санал хураая.

Байнгын хорооны хуралдаанаар.

Дэмжигдлээ шүү дээ. Байж байгаарай. Тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулья. Танилцуулчихсан.

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Ажлын хэсэг байгуулгахыг дэмжсэнгүй ээ.

Байнгын хорооны хурал дууссаныг мэдэгдье.

17.53 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*